



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,  
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2024. 07. 09

№

04/1486

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөвлөмж хүргүүлэх тухай**

Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байгаатай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүнд өндөр насны тэтгэвэр тогтоохтой холбоотой асуудлаар тус газраас Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс чиглэл хүссэний дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газраас ирүүлсэн чиглэлийг хэрэгжүүлэх талаар дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүнийг насны тэтгэвэрт гарах үед нь Цэцийн гишүүний цалингийн 60 хувиар бодож тэтгэвэр тогтоож болно. Тэтгэврийг нийгмийн даатгалын сангаас олгоно” гэж заасны дагуу Үндсэн хуулийн Цэцийн гишүүнээр ажиллаж байсан бүх хүнийг тухайн Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа (6 жил)-нд бүтэн ажилласан эсэхээс үл хамааран Цэцийн гишүүн гэж үзэж өндөр насны тэтгэвэр тогтооно.

2. Цэцийн гишүүний өндөр насны тэтгэвэр тогтоолгох цалин хөлс гэдгийг түүний тэтгэвэр тогтоолгох үед мөрдөж байгаа Улсын Их Хурал (2024 онд Улсын Их Хурлын 2023 оны “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 117 дугаар тогтоолоор баталсан цалин)-аас тогтоон баталсан Цэцийн гишүүний цалин болон Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлд заасан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна. Цэцийн гишүүний сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлого нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээнээс хэтрэхгүй байна. (2024 онд 6 600 000 төгрөг байна.)

3. Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүний өндөр насны тэтгэврийн насыг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2 дахь хэсэгт заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийг 25-аас доошгүй жил төлсөн эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 насыг баримтлах бөгөөд Цэцийн гишүүнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтооно.

4. Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүнд өндөр насны тэтгэврийг энэ зөвлөмжийн 2 дахь хэсэгт заасан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос 60 хувиар, 25 жилээс илүү төлсөн жил тутамд 1.5 хувиар, сар тутамд 0.125 хувиар нэмэгдүүлэн бодно. Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүн өндөр насны тэтгэвэр тогтоолгосноос хойш албан журмын даатгалд хамрагдаж нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан тохиолдолд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт заасны дагуу тэтгэвэр авагчийн анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр тогтоолгосноос хойш ажиллаж шимтгэл төлсөн жил тутамд 1.5 хувь, сар тутамд 0.125 хувиар тооцож нэмэгдүүлнэ.

5. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Даатгуулагч нийгмийн даатгалын сангаас хоёр ба түүнээс дээш төрлийн тэтгэвэр тогтоолгон авах эрх зэрэг үүсвэл өөрт таатай нөхцөлтэй нэг төрлийн тэтгэврийг нэг удаа

сонгоно” гэж заасны дагуу Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүн өндөр насны тэтгэвэр тогтоолгох үед Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу бодсон тэтгэврээс илүү таатай нөхцөлтэй тэтгэврийг сонгон тогтоолгоно.

Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын 2024 оны “Хариу хүргүүлэх тухай” ТГ-2/223 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийг хүргүүлэв.

Хавсралт 4 хуудастай.

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ГАЗРЫН ДАРГА



Ц.ГАНЦЭЦЭГ



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА Л.МӨНХЗУЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН  
ТАМГЫН ГАЗАР

17023 Улаанбаатар хот,  
Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо, Зайсангийн гудамж 11,  
Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн байр,  
Утас: 26 71 40, 26 01 09, Факс: (976-51) 26 71 74,  
И-мэйл: interdept@conscourt.gov.mn

2024.05.22 № ТТ-2/223  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хариу хүргүүлэх тухай

Танай 2024 оны 01/475 дугаар албан бичгээр Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүн өндөр насны тэтгэвэр тогтоолгохтой холбоотой хууль тогтоомжийг хэрхэн ойлгож хэрэгжүүлэх асуудлаар тайлбар авахаар ирүүлсэн хүсэлттэй танилцаад үүгээр хариу хүргүүлж байна.

Үндсэн хуулийн цэцийн гишүүний эрх зүйн байдлыг нарийвчлан зохицуулсан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн Үндсэн хуулийн цэцийн гишүүний баталгаа гэсэн 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт Улсын Их Хурлаас 1997 онд "Үндсэн хуульд заасан бүрэн эрхийн хугацаагаар Цэцийн гишүүнээс чөлөөлөгдсөн хүнийг насны тэтгэвэрт гарах үед нь Цэцийн гишүүний цалингийн 60 хувиар бодож тэтгэвэр тогтооно." гэж, 1999 онд уг зохицуулалтад "Тэтгэврийг нийгмийн даатгалын сангаас олгоно." гэж тус тус нэмсэн. Харин уг заалтыг 2016 онд өөрчлөн найруулахдаа "Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүнийг насны тэтгэвэрт гарах үед нь Цэцийн гишүүний цалингийн 60 хувиар бодож тэтгэвэр тогтоож болно. Тэтгэврийг нийгмийн даатгалын сангаас олгоно." гэж хуульчилсан бөгөөд одоо хүчин төгөлдөр үйлчилж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд дээрх нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан хуулийн үзэл баримтлал, танилцуулга болон Улсын Их Хурал уг асуудлыг хэлэлцсэн дэлгэрэнгүй тэмдэглэлийг судлан үзэхэд хууль тогтоогчоос Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгааг хангах, цэргийн болон зарим онцгой албан тушаалын хүмүүсийн тэтгэврийг цалингийн 60 хувиар тогтоосонтой адилтган тэтгэврийн хэмжээг өндөр тогтоохыг зорьсон байна. Иймд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Цэргийн алба хаасны тэтгэврийг тэтгэвэр тогтоолгогчийн сарын дундаж цалин хөлсний 80 хувиар тогтооно.", 2 дахь хэсэгт "Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан хугацаанаас илүү алба хаасан жил тутамд 1.5, сар тутамд 0.125 хувиар цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон цалин хөлснөөс тооцож нэмэгдэл олгоно." гэж хуульчилсны дагуу цэргийн алба хаагч нь алба хаасны тэтгэврийг сарын дундаж цалин хөлсний 80 хувиар тогтоолгож, тодорхой хувиар нэмэгдэл олгодог зохицуулалттай Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүний өндөр

насны тэтгэврийг адилтган тогтоохыг зорьсон байгаа тул энэхүү хуулийн заалтыг жишиг болгон тогтооход харшлах зүйлгүй гэж үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн дээрх заалт болон уг хуульд тусгайлан хуульчлаагүй боловч тухайн асуудлыг зохицуулсан бусад холбогдох хуулийн зохицуулалтыг судлан үзээд танай албан бичигт дурдсан асуудлуудыг хэрхэн ойлгож хэрэгжүүлэх талаар дараах тайлбарыг хүргүүлж байна:

1. "Цэцийн гишүүнээр ажиллаж байгаад чөлөөлөгдсөн хүн" гэсэнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хугацаагаар буюу бүтэн зургаан жил ажиллаад Цэцийн гишүүнээс чөлөөлөгдсөнөөс хойш өөр ажил хийж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн хүнийг хамааруулан ойлгох эсэх талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт "Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүнийг насны тэтгэвэрт гарах үед нь Цэцийн гишүүний цалингийн 60 хувиар бодож тэтгэвэр тогтоож болно. Тэтгэврийг нийгмийн даатгалын сангаас олгоно." гэж зааснаар Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилогдон ажиллаж байсан бүх хүн ажилласан хугацаанаас үл хамааран уг заалтын дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй байна.

2. "Цэцийн гишүүний цалин" гэснийг тухайн даатгуулагчийн Цэцийн гишүүн байх үедээ авч байсан цалин хөлс биш түүнийг өндөр насны тэтгэвэрт тогтоолгох хүсэлт гаргах үед Улсын Их Хурлаас тогтоосон Цэцийн гишүүний цалин гэж ойлгох эсэх талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт "Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүнийг насны тэтгэвэрт гарах **үед нь Цэцийн гишүүний цалингийн 60 хувиар бодож тэтгэвэр тогтоож болно.** Тэтгэврийг нийгмийн даатгалын сангаас олгоно." гэж заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүн тэтгэвэрт гарах үедээ тухайн үеийн Цэцийн гишүүний цалингаас тооцуулан тогтоолгохоор байна.

Харин Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17 дахь заалтад цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг Төрийн албаны тухай хуульд заасан цалин хөлс, сар, улирал, жил тутам, эсхүл тухайн тохиолдол бүрд олгож байгаа шагнал, урамшуулал, хоол, унаа, орон сууцны ашиглалтын төлбөр, мөнгөн хэлбэрээр олгосон хөнгөлөлт байхаар хуульчилсан бөгөөд Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлд төрийн албан хаагчийн цалин нь албан тушаалын цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс бүрдэхээр, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 20 дугаар зүйлд тэтгэвэр тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлоготой уялдуулж тодорхойлох талаар тус тус хуульчилсан байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан Үндсэн хуулийн цэцийн гишүүний цалин гэснийг Үндсэн хуулийн цэцийн гишүүний тухайн үеийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн албан тушаалын цалин болон нэмэгдэл, нэмэгдэл хөлс гэж ойлгохоор байна.

3.“Цэцийн гишүүний цалингийн 60 хувиар бодож тэтгэвэр тогтоож болно.” гэснийг тухайн даатгуулагчийн 30 жил ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэвэр бодох хувь гэж ойлгож 30 жил (360 сар)-ээс дээш илүү ажиллаж шимтгэл төлсөн сар тутамд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д заасны дагуу 0.125 хувийн нэмэгдэл тооцож олгох эсэх талаар

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан хугацаанаас илүү алба хаасан жил тутамд 1.5, сар тутамд 0.125 хувиар цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон цалин хөлснөөс тооцож нэмэгдэл олгоно.” гэж хуульчилсны дагуу цэргийн алба хаагчид нэмэгдэл олгодогтой адилтган Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүнд тэтгэвэр тогтооход Нийгмийг даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 7.2-т заасан нэмэгдлийг тэтгэвэр авагчийн анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр тогтоолгосноос хойш шимтгэл төлсөн сар тутамд 0.125 хувиар тооцож бодно.” гэж хуульчилсан нэмэгдэл тооцох нь зүйтэй.

4.Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүний өндөр насны тэтгэвэр тогтоох насыг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт, мөн заалтын тайлбарт зааснаар мөрдөх эсэх, Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүн төрсөн ондоо харгалзах өндөр насны тэтгэврийн насанд хүрээгүй байхдаа тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргавал хэрхэн шийдвэрлэх талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүн тэтгэвэр тогтоолгоход тодорхой насанд хүрсэн байх тусгай нөхцөл хуульчлаагүй байх тул Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад заасан тэтгэврийн насанд хүрсэн эсэхээс үл хамааран Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу тэтгэвэр тогтооно гэж ойлгогдож байна.

5.Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүний ажиллаж байсан нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг хэрхэн мөрдөх талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх тодорхой хугацаа хуульчлаагүй. Түүнчлэн, хууль тогтоогчоос тухайн үед Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүний нийгмийн баталгааг хангаж өндөр насны тэтгэвэр тогтоолгоход цэргийн болон зарим онцгой албан тушаалын хүмүүсийн тэтгэврийг цалингийн 60 хувиар тогтоосонтой адилтгахаар зорьсон бөгөөд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд тус тус зааснаар цэргийн алба хаагчид алба хаасан хугацаанд үндэслэн тэтгэвэр олгохоор хуульчилсан. Иймд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилогдон ажиллаж байсан хүн 25 жил улсад ажилласан тохиолдолд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтооно.

Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Даатгуулагч нийгмийн даатгалын сангаас хоёр ба түүнээс дээш төрлийн тэтгэвэр тогтоолгон авах эрх зэрэг үүсвэл өөрт таатай нөхцөлтэй нэг төрлийн тэтгэврийг нэг удаа сонгоно.” гэж заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан тэтгэвэр бодох аргачлалаас өөрт илүү таатай нөхцөлтэй буюу эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийн заалтыг сонгон өндөр насны тэтгэврээ тогтоолгох эрхтэй байна.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүний өндөр насны тэтгэвэр тогтоолгох асуудлыг цаашид шийдвэрлэхдээ илүү нарийвчлан зохицуулсан хууль болох Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн зохицуулалтыг хэрэглэж Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүний эрх зүйн байдлыг дордуулахгүй байх, тэтгэвэр авагч өөрт таатай нөхцөлтэй нэг төрлийн тэтгэврийг сонгох зарчмыг баримтлахыг анхаарна уу.

Хүндэтгэсэн,

ДЭД ДАРГА



Г.ДАВААДАЛАЙ